

ТАНИЛЦУУЛГА

*Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Хүн амын худалдан авах чадварт нийцсэн, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийхээр заасан. Энэ хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууц барих, худалдан авахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, цахим татварын тогтолцоог сайжруулах, бүс, орон нутагт ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, иргэн, өрхийн бодит орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, бүх нийтээрээ тэгш шударга татвараа төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжинэ.
- Татвар төлөгчийн татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулж, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, тэдний бодит орлого өсөх, худалдан авах чадвар нэмэгдэх, өрхийн амьжиргаа дээшлэх, бүс орон нутаг бие даасан, өрсөлдөхүйц, ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах зэрэг эерэг үр дагавартай байна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Хүн амын худалдан авах чадварт нийцсэн, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалтыг эрчимжүүлэх”, “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр тус тус заасан. Үүний хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц барих, засварлахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бүс, орон нутагт ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, иргэн, өрхийн бодит орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь бичил, жижиг хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах үндсэн зорилготой байсан.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгийн өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болсон.

Монгол Улсын хувьд инфляцын түвшин нэмэгдэж, 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 9.0 хувьд хүрсэн ба энэ нь голчлон бага дунд орлоготой иргэн, өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж, тэдний бодит орлого, худалдан авах чадварыг бууруулж байна.

Дэлхийн улс орнууд орлогын дахин хуваарилалт хийх үндсэн зорилго бүхий хувь хүний орлогын албан татварын бодлогоор иргэн, өрхөд татварын дэмжлэг үзүүлж, тэдний татварын дараах орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч

хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс зэрэг олон улс орнууд иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашлаад эрчим хүчний хэмнэлтийг бий болгох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй иргэдийн орлогод болон тэдний худалдан авсан ногоон орон сууцанд албан татварын хөнгөлөлтийг буцаан олголтоор эдлүүлж, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих бодлогыг баримталж байна.

Улмаар хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувь хүний орлогын албан татварын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх шаардлага бий болоод байна.

Түүнчлэн хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суух иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилгыг нэмэгдүүлэх, бүс, орон нутгийн эдийн засгийн бие даасан бодлого хэрэгжүүлэх нөхцөлийг хууль эрх зүйн хүрээнд бүрдүүлэх, боловсронгуй болгох татварын хуулийн шинэчлэл хийх нь зүйтэй байна.

Цаашид татвар төлөгчийн татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан бэлтгэн хүргүүлдэг, татварын эрсдэлийг цахим систем өөрөө үнэлж, эрсдэлтэй татвар төлөгчдөд урьдчилан анхааруулдаг, сануулдаг тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

Хуулийн төслийн зорилго нь татварын хөнгөлөлтийг оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй худалдан авалтыг дэмжих болон татвар төлөгчийн татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Энэ хүрээнд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар нийт 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулан 176 мянга гаруй санал, хүсэлт хүлээн авсан. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд бүх нийтээрээ тэгш шударга татвараа төлөх, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх, татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулах, бизнес эрхлэгчдэд нийтлэг тулгарч буй хүндрэл, асуудлыг шийдвэрлэх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Хуулийн төсөлд үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, дараах холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1.Татварын хөнгөлөлтийн бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох замаар иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд шаталсан татварын хөнгөлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зохицуулалтыг тусгалаа.

2.Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний татварын ачааллыг бууруулах, бүх нийтээрээ татвараа тэгш шударга төлөх татварын орчныг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлд татварын тогтолцооны суурь зарчим болох тэгш шударга байх үндсэн дээр үйл ажиллагааны орлогыг шатлалд хамрагдуулах, хялбаршуулсан горимоор тайлагнах босго дүнг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулах, үйл ажиллагааны орлоготой иргэдэд татварын хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалтыг тусгалаа.

3.Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжиж, бүс, орон нутаг хүн ам, ажиллах хүч татах ялгаатай татварын бодлогыг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суух иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилгыг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжих зохицуулалтыг тусгалаа.

4.Татварын тайланг цахимаар урьдчилан боловсруулж, татвар төлөгчийн төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд татвар төлөгчийг үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зорилгоор татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан бэлтгэн хүргүүлдэг зохицуулалтыг тусгалаа.

5.Хэлэлцүүлгийн явцад олон нийтээс ирүүлсэн саналуудыг судлан үзэж, зарим арга хэмжээнүүдийг хуулийн төсөлд нэмж тусгав.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах судалгааны хамт Сангийн яамны албан ёсны цахим хуудсанд 60 хоногийн хугацаанд байршуулж, олон нийтээс санал авсан. Эдгээр санал болон уулзалт, хэлэлцүүлгийн явцад татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг нэгтгэн авч үзвэл Хувь хүний орлогын албан татварын тухай хуультай холбоотой нийт 30,450 саналыг ирүүлсэн бөгөөд саналуудыг нэг тус бүрчлэн судлан үзсэн.

Хуулийн төсөл боловсруулах явцад татвар төлөгчдөөс хялбаршуулсан горимын зохицуулалтыг хэвээр үлдээж, бүх нийтээрээ татвараа төлдөг, татварын шударга байх зарчмын хүрээнд тус горимд хамрагдах босго дүнтэй байх, бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчийн ялгаатай хувь хэмжээгээр төлж байгааг өөрчлөх зэрэг саналыг ирүүлсэн. Эдгээр саналыг судлан үзэж, хуулийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусгасан.

Харин Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмж болон татвар төлөгчдийн саналд үндэслэн олон нийтээс санал авахаар байршуулсан хуулийн

төсөлд тусгагдсан Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгжийн хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид олгосон тухайн хувьцааны ногдол ашгийн орлогод ногдуулах татварын хувь хэмжээг өөрчилсөн зохицуулалтыг төслөөс хассан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, тэдний бодит орлого өсөх, худалдан авах чадвар нэмэгдэх, өрхийн амьжиргаа дээшлэх, бүс орон нутагт хүн ам татах, бүсийн бие даасан, өрсөлдөхүйц, ялгаатай бодлого хэрэгжүүлэх боломж бүрдэх, татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах зэрэг эерэг үр дагавартай байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсрууллаа.

---oOo---